ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 21 өдөр Дугаар А/698 Арвайхээр

Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн хуваарийг нэгдүгээр, сумдын Засаг даргын Тамгын газрын төсвийн хуваарийг хоёрдугаар, ерөнхий боловсролын сургуулийн төсвийн хуваарийг гуравдугаар, цэцэрлэгүүдийн төсвийн хуваарийг дөрөвдүгээр, соёлын төвийн байгууллагуудын төсвийн хуваарийг тавдугаар, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний байгууллагуудын төсвийн хуваарийг зургаадугаар, аймгийн төсвийн шууд байгууллагуудын төсвийн хуваарийг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Төсвийн санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгож, төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/632 дугаар захирамжийн гуравдугаар, дөрөвдүгээр, тавдугаар, зургаадугаар, долоодугаар, наймдугаар, есдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Г.ГАНБОЛД

011101521

D:My Doc. Zahiramj. Zasag darga